



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж, ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 34,100,000.00 (гучин дөрвөн сая нэг зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 17,050,000.04 (арван долоон сая тавин мянган төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж, ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэх төрийн өмчийн төлөөлөгч Б.Билгүтэд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөгчийг оруулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Автомашиныг худалдсаны дараа автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132001128
14-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн
037 дугаар тогтоолын хавсралт

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ, АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН
ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, улсын болон хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Тоёота Веллфайре, 47-24 УАЕ, АНН258028933	2011/2020	34,100,000.00	17,050,000.04	17,049,999.96	20,000,000.00
Нийт дүн			34,100,000.00 (гучин дөрвөн сая нэг зуун мянга)	17,050,000.04 (арван долоон сая тавин мянга дөрвөн мөнгө)	17,049,999.96 (арван долоон сая дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн мянга ерэн зургаан мөнгө)	20,000,000.00 (хорин сая)